



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/175

Номгон

Залуучуудын хөгжлийг дэмжих салбар  
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн байгуулсугай.

2.Орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан сумын түвшинд хэрэгжилтийг хангах орон тооны бус салбар зөвлөлийг байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Аймаг, сумын салбар зөвлөлийн хамтын ажиллагааг уялдуулан үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлд үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

5.Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/196 дугаар захирамжийг хучингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642310447

88  
Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дүгээр сарын \_\_\_\_\_ ны  
өдрийн \_\_\_\_\_ дугаар захирамжийн хавсралт



## ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дэд тэргүүн: Засаг даргын орлогч

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Боловсрол шинжлэх ухааны газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн

Аймгийн Залуучуудын холбооны Тэргүүн

“Жаргалтай амьдрал” төвийн дарга

“Үүрэгтэй залуус” төрийн бус байгууллагын тэргүүн

Хүний эрхийн үндэсний комиссын Баянхонгор аймаг дахь салбарын референт (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга